



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/714
танай -ны № -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИХ-УУЛ
СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ХИШИГБАТ
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

МАЛГАЧИЙН ТӨГЛӨЛ
ХҮЧИЙН НӨХЦЭЛ/УЧИРЫН

СҮРХҮҮЛСЭН
СҮРХҮҮЛСЭН
СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

СҮРХҮҮЛСЭН

Боловсруулсан

Хянасан

Хувь:

Огноо: 2024.08.05

Х.Түншээжаргал
Х.Түншээжаргал

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Монгол Ардын намын хорооны ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Монгол Ардын намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (12 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Монгол Ардын намын хороонд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт 12 хуудастай.



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

1

Сумын МАН-ын хорооны Тэргүүлэгчдийн

2024 оныр сарын....өдрийнр тогтоолоор батлав.



Их-Уул сумын ИТХ-ын 2024 оны сонгуульд МАН-аас дэвшүүлж буй мөрийн хөтөлбөр

Үндэслэл:

- ✓ Намын гишүүд дэмжигчдээс ирүүлсэн санал
- ✓ “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн хөтөлбөр
- ✓ “Хөгжсөн Хөвсгөл 2030” хөтөлбөр
- ✓ Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд Монгол Ардын Намаас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого бүсчилсэн хөгжлийн реформ” мөрийн хөтөлбөр
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль

Уриа: **ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ХАМТДАА**

Зорилго: **Орон нутгийн хөгжил, иргэдийн амьжиргааны чанарыг сайжруулахад чиглэгдэнэ.**



1

ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

2

АГУУЛГА

НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 1.1 Эрүүл мэнд
- 1.2 Боловсрол
- 1.3 Хүн ам, нийгмийн хамгаалал
- 1.4 Соёл, спорт

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

- 2.1 Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр, бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин
- 2.2 Аялал жуулчлал
- 2.3 Эрүүл хүнс
- 2.4 Хөдөө аж ахуй

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

- 3.1 Хүний эрх
- 3.2 Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа
- 3.3 Ухаалаг “E-Mongolia” AI шинэчлэл- Цахим засаглал
- 3.4 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 4.1 Уламжлалт нүүдлийн аж ахуй ба сорилт бэрхшээл
- 4.2 Ногоон эдийн засаг

ТАВ. ДЭД БҮТЭЦ



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1. Эрүүл мэнд

- 1.1.1. Орон нутгийн төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг бэхжүүлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлж, чадварлаг, ёс зүйтэй хариуцлагатай хүний нөөцийг төлөвшүүлэнэ.
- 1.1.2. Өвчинөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлнэ.
- 1.1.3. Эрүүл амьдралын хэв маягийг дэмжсэн дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох, өвчинөөс урьдчилан сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй зохион байгуулна.
- 1.1.4. “ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” “ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ ШҮД” “УМАЙН ХҮЗҮҮН ХАВДАРГҮЙ МОНГОЛ” хөтөлбөрүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 1.1.5. Эмнэлэгийн ажиллагсдын нийгмийн асуудал, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, тэднийг гадаад дотоодын чадавхижуулах, мэргэшүүлэх сургалтуудад хамруулахыг дэмжинэ.
- 1.1.6. “Эмийн зохистой хэрэглээ” аяны хүрээнд нэн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтыг нэмэгдүүлж, эмийн чанар, аюулгүй байдалд тавих, иргэд олон нийт төрийн хяналтыг сайжруулна.

1.2. Боловсрол

1.2.1. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрт сууринсан арга хэмжээг үр дүнд хүргэх

- 1.2.1.1. “ОРОН НУТАГ СУДЛАЛ” хичээлийг чиглэлээр зохион байгуулж, үр дүнд хүргэнэ. /Орон нутгийн ёс заншил, Орон нутгийн түүх, Орон нутгийн МАА, Орон нутгийн газар зүй/
- 1.2.1.2. Хүүхэд бүрийн чадвар-хөгжлийн судалгаа төвтэй “ДЭЛХИЙД ӨРСӨЛДӨХ ХӨВСГӨЛИЙН ХҮҮХДҮҮД” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

4

- 1.2.1.3. “АХЛАХ СУРГУУЛЬ” хөтөлбөрийг цахим болон танхимын хэлбэрээр туршин хэрэгжүүлнэ.

1.2.2. Хүүхэд хөгжил, хамгааллыг бодит байдалд суурилж хөгжүүлэх

- 1.2.2.1. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдвал зохих хүүхдүүдийг бүрэн хамруулж, анги дүүргэлтийг стандартын түвшинд байлгана.
- 1.2.2.2. Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, яслийн үйлчилгээг сэргээнэ.
- 1.2.2.3. Цэцэрлэгийн хүүхдийн хоол болон сургуулийн үдийн хоолны стандарт, чанарт өөрчлөлт гаргах, орц найрлагыг нэмэгдүүлэх, шим тэжээл, амин дэмээр баялаг хоол, сүү, сүүн бүтээгдэхүүнээр үйлчлэхийг зорино

1.2.3. Багшийн хөгжил, нийгмийн баталгаа, үнэлэмжийг нэмэгдүүлэх

- 1.2.3.1. Багш нарын эрүүл мэндийн байдал, ажлын үр бүтээмжийг сайжруулах зорилгоор амрах, алжаал тайлах фитнес өрөө бий болгохыг дэмжинэ.
- 1.2.3.2. “АНГИ УДИРДАГЧ БАГШ” орон нутгийн урамшуулал-хөтөлбөрийг дэмжин хэрэгжүүлнэ.
- 1.2.3.3. Багш нарын ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, тэднийг гадаад дотоодын сургалтанд хамруулан чадавхижуулах, сургуулийг сэтгэл зүйч, цэцэрлэгийг нийгмийн ажилтантай болгох асуудлыг мэргэжлийн байгууллагуудад тавина.

1.2.4. Суралцахуй төвтэй орчныг бүрдүүлэх

- 1.2.4.1. ЕБС-ийн харьяа биеийн тамир, спортын “ГАДНА” талбайг тохижуулж суралцагчдын хөнгөн атлетик, хөл бөмбөгөөр хичээллэх орчныг сайжруулна.
- 1.2.4.2. ЕБС-д байгалийн ухааны хичээлийн туршилтын талбайг шинээр бий болгож нарийн ногоо болон хүнсний ногооны байнгын хүлэмж ажиллуулахыг дэмжинэ.

1.3. Хун ам, нийгмийн хамгаалал



4

ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

5

- 1.3.1. Хүн амынхаа нийгмийн бүлэг /хүүхэд, залуучууд, ахмад настан, эхчүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд/ бүрт чиглэсэн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслүүдийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 1.3.2. Хүүхдийн бодит оролцоо, хэрэгцээнд сууринсан хөгжлийн үйлчилгээг дэмжинэ.
- 1.3.3. Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгаалалын үйлчилгээг сайжруулан гэр бүл, хүүхэд хөгжил хамгаалалын нийгмийн ажилтантай болохыг дэмжинэ.
- 1.3.4. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлт нөхцөл байдал тулгарсан үед авах арга хэмжээний мэдлэг, чадавхийг хүүхэд, өсвөр үеийнхэнд төлөвшүүлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ.
- 1.3.5. Гэр бүлийн гишүүд, эцэг, эхчүүдийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, хандлага өөрчлөх, гэр бүлийн хөгжлийг дэмжих ажлыг салбар дундын хамтын ажиллагааны хүрээнд эрчимжүүлнэ.
- 1.3.6. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод чиглэсэн үйлчилгээ, орчин нөхцөлийг стандартад нийцүүлж, хамтарсан багийн ажлын үр нөлөөг дээшлүүлнэ.
- 1.3.7. Залуучуудын бизнес эрхлэх боломж, гарцааны бизнес эрхлэх нөхцөлийг нэмэгдүүлнэ.
- 1.3.8. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.3.9. Зудад өртсөн малчдыг малжуулах хөтөлбөрийг дэмжиж, малын тоо бус чанарыг чухалчилна.
- 1.3.10. Хөдөө аж ахуйн даатгалын тогтолцоог сайжруулж, малчид, тариаланчдыг эрсдэлээс хамгаална.
- 1.3.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тэгш хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.
- 1.3.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.
- 1.3.13. “Халамжаас хөдөлмөрт” бодлогын хүрээнд зорилтот бүлгийн иргэдийг тогтвортой ажилд зөвлөн чиглүүлэх, ур чадвар эзэмшигүүлэх хөтөлбөрт хамруулан зуучлах үйлчилгээний тогтолцоог хөгжүүлнэ.

5



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

- 6
1.3.14. Төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусlamж, үйлчилгээг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.


1.4. Соёл, спорт

- 1.4.1. Соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхижуулж хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар стандарт хангасан чанартай, хүртээмжтэй үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 1.4.2. “Соёл урлаг” хөтөлбөр баталж соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлээр төсөл арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 1.4.3. Соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сайжруулж, аялагчдын аялах таатай орчныг бий болгоно.
- 1.4.4. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг дэмжиж бүх нийтийг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.4.5. Өсвөр үеийн хүүхэд залуусыг спортын олон төрлөөр хичээлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн спортын амжилтыг дэмжин ажиллана.

ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Хөдөлмөр эрхлэлт, шинэ ажлын байр, бизнес хөрөнгө оруулалтын таатай орчин

- 2.1.1. Салбар хоорондын хамтын ажиллагааг өрнүүлэх замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 2.1.2. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийг бий болгож орчин нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.1.3. Хувийн хэвшил, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар шинэ ажлын байрыг бий болгоно.
- 2.1.4. Ахуйн үйлчилгээний төв бий болгож хувиараа хөдөлмөр эрхэлж буй болон бизнесээ эхэлж буй иргэдийг дэмжиж ажиллана.



- 2.1.5. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж буй хөдөлмөрийн насын иргэдийг түр болон цагийн ажлын байранд зуучлах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 2.1.6. Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй хөдөлмөрийн насын иргэдийг жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн аймаг, бусад орны туршлага судлуулахад хамтарч ажиллана.
- 2.1.7. Нийтийн эзэмшлийн зам талбайд үйлчилгээ эрхлэх боломжийг иргэдэд олгоно.

2.2. Аялал жуулчлал

- 2.2.1. Нүүдлийн соёл, орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан хөгжүүлж орон нутагт орох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.
- 2.2.2. Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээл, худалдааны сувгуудаар дэмжих бодлого баримтална.
- 2.2.3. Аялагч, жуулчдад үйлчлэх үйлчилгээний газруудын ариун цэврийн байгууламж, түр буудаллах цэг, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.
- 2.2.4. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.3. Эрүүл хүнс

- 2.3.1. Эко хүнс үйлдвэрлэгч болзол журам хангасан иргэд аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжиж, эко хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл тоог өсгөж, зах зэлийн хүрээг нэмэгдүүлнэ.
- 2.3.2. Үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн стандарт шаардлага хангасан орчин үеийн техник технологи бүхий хөргүүртэй мал нядалгааны цэг бий болгоно.

2.4. Хөдөө аж ахуй

2.4.1. Мал аж ахуй

- 2.4.1.1. “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд иргэд хоршоолохыг дэмжинэ.
- 2.4.1.2. Мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар хоршоог дэмжинэ.



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

8

- 2.4.1.3. Зудын эрсдэлийг даван туулах “ӨВӨЛЖӨӨ” төсөл хэрэгжүүлж малын хашаа хороог сайжруулах зорилгоор малчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр мод бэлтгэх боломж бүрдүүлнэ.
- 2.4.1.4. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх шалгарсан арга аргачлалыг сурталчилж, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд дутагдалтай малын эмч, мал зүйч, зоотехникч мэргэжилтэн бэлтгэх бодлого баримтална.
- 2.4.1.5. Малчдын боловсрол, эрүүл мэнд, нийгэм, соёлын үйлчилгээг хоршоогоор дамжуулан шинэ түвшинд гаргана
- 2.4.1.6. Хоршоололд суурилсан хагас эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг дэмжинэ.
- 2.4.1.7. Малчид хоршоолох замаар мах, сүү, арьс шир боловсруулах цех байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллана.
- 2.4.1.8. Малчин өрхөд тэжээлийн ургамал, хүнсний ногоо тариалах зорилгоор өвөлжөө, хаваржааны ойролцоо газрыг эргэлтэнд оруулж ашиглуулах /1 өрхөд 1 га хүртэл/
- 2.4.1.9. Малын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллана.
- 2.4.1.10. Стандартын шаардлага хангасан хээлтүүлэгч бэлтгэн нийлүүлж буй мэргэжлийн байгууллага, малчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.1.11. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- Мал амьтнаас хүнд халдвартадаг халдварт өвчний хяналт, хариу арга хэмжээний бэлэн байдлын ханггуулж ажиллана.
 - Хашаа хорооны халдвартагийг чанартай зохион байгуулж халдварт шимэгчдээс урьдчилан сэргийлнэ.
- 2.4.1.12. Малын чанар үүлдэр угсааг сайжруулна.
- Гоц халдварт өвчингүй тайван бус нутаг болох зорилт дэвшүүлж хэрэгжүүлнэ.
- 2.4.1.13. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицож эрсдэлийг даван туулах чадвартай мал аж ахуйг хөгжүүлнэ.

8





- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг гарал үүслийг тодорхой болгох, малыг зэмэгжүүлж, бүртгэл мэдээллийг нэгдсэн санд оруулах ажлыг эрчимжүүлнэ.
- Малын тэжээлийг нэмэгдүүлэх замаар ашиг шимиийн улирлын хамаарлыг бууруулна.
- Баталгаажсан үүлдэр омгийн малын ашиг шимиийг тогтоож, мал аж ахуйн нэгдсэн санд бүртгэх, цаашид хамгаалах, ашиг шимиийг нэмэгдүүлэх бодлого баримтлана.

2.4.2. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл

- 2.4.2.1. Малчдад сургалт мэдээллийг үе шаттай зохион байгуулж туршилт судалгааг хамтран зохион байгуулна.
- 2.4.2.2. Мал үргүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжийг бий болгон дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.2.3. Мал аж ахуйн дэвшилтэд технологийг ашиглаж, малын ашиг шимиийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.2.4. Малын гаралтай бүтээгдэхүүнийг үнэ цэнийг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг нэмэгдүүлнэ.
- 2.4.2.5. Зөгийн аж ахуйг эрчимтэйгээр дэмжиж, зөгийн балын брэндийг бий болгоно.
- 2.4.2.6. Гадаад дотоодын жуулчдыг малчин өрхөөр зочлуулах арга хэмжээг зохион байгуулах, нүүдлийн соёл, бэлчээрийн мал аж ахуйг сурталчлах үүнээс орлого олох боломжийг бий болгоно.
- 2.4.2.7. Ашиглагдахгүй байгаа бэлчээрийг ашиглах худаг ус гаргана.
- 2.4.2.8. Малын түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх хоршооллыг дэмжиж ажиллана.
- 2.4.2.9. Бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлэх нөхцөл бүрдүүлж ажиллана.
- 2.4.2.10. Малчид, тариаланчдын залгамж халааг бэлтгэх аяныг хэрэгжүүлнэ.



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

10

ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Хүний эрх

- 3.1.1. Цахим орчин дахь ялгаварлал, хүчирхийлэл, тэгш бус байдлыг бууруулж, хамгаалах бодлого хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 3.1.3. Төрийн байгууллагын шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, хүний эрхийг зөрчсөн аливаа шийдвэр гаргахгүй байхад анхаарна.
- 3.1.4. Бүх нийтэд хүний эрх, жендерийн боловсрол олгож, бүх түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах бодлого баримтална.
- 3.1.5. Зайлшгүй шаардлагатай асуудлаар хяналт хийх “Нээлттэй сонсгол”-ыг зохион байгуулж, иргэдийн мэдэх эрхийг хангана.

3.2. Төрийн албаны хүний нөөцийн бодлого ба нийгмийн баталгаа

- 3.2.1. Чадахуйн зарчимд сууриссан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, бүх нийтийн шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээг цахимжуулан чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 3.2.2. Албан тушаалтны буруутай шийдвэрээс болж хохирсон төрийн албан хаагчийн хохирлыг буруутай этгээдээс барагдуулах ажиллагааг зохион байгуулна.
- 3.2.3. Суманд дутагдалтай байгаа боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах бодлого баримтална.
- 3.2.4. Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага, ажлын гүйцэтгэл, үр дүнд сууриссан урамшууллын тогтолцоог хэрэгжүүлнэ.
- 3.2.5. Төрийн албаны хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх “Сургалт”, “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” төсөл хөтөлбөрүүдийг дэмжиж ажиллана.
- 3.2.6. Төрийн албан хаагч нь улс төрөөс ангид, дарамтгүй ажлаа хийх боломжийг бүрдүүлнэ.
- 3.2.7. Төрийн албан хаагчдын цалин хөлсөнд нийцсэн ипотекийн зээлд багш, эмч нарыг хамруулж хөнгөлттэй үнээр орон сууцжуулах бодлого баримтална.

10

0000000010

3.3. Ухаалаг “E-Mongolia”AI шинэчлэл- Цахим засаглал

- 3.3.1. Төрийн бүх үйлчилгээ цахим хэлбэрт шилжүүлэхийг чухалчилж “ E- Mongolia” системийн хүртээмжийг нэмэгдүүлж, “ХҮР-ДАН” төвийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.3.2. Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулан шилэн ажиллагааг үргэлжлүүлнэ.
- 3.3.3. Иргэний бүртгэл, үл хөдлөх хөрөнгө, газрын бүртгэл, харилцаанд “блокчейн” технологийг ашиглан маргааныг бууруулна.


3.4 Иргэдэд ойр төрийн үйлчилгээ

- 3.4.1. Төр, иргэн, хувийн хэвшил цахимаар мэдээлэл солилцох дэд бүтцийг сайжруулж, иргэд бизнест төвөггүй хялбар үйлчилгээг үзүүлнэ.
- 3.4.2. Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж, төр иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлнэ.
- 3.4.3. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн хяналтыг сайжруулна.
- 3.4.4. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх олон нийтийн хяналтыг бий болгоно.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Уламжлалт нуудлийн аж ахуй ба сорилт бэрхшээл

- 4.1.1. Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, газрын доройтол, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээ авна.
- 4.1.2. Бэлчээрийн мал аж ахуйд зохистой сургийн бүтэц, ашиг шимт байдал, байгальд ээлтэй мал маллах зөв дадлуудыг нэгтгэсэн стандартыг нэвтрүүлж, бэлчээрийн доройтлыг бууруулна.
- 4.1.3. Газар ашиглагчдын хариуцлагыг нэмэгдүүлж, цөлжилт, газрын доройтлыг бууруулна.



ИХ-УУЛ СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024

12

4.2. Ногоон эдийн засаг


- 4.2.1. Ногоон хөрөнгө оруулалт, гадаад зээл тусlamжид хамрагдах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Ногоон технологи, инновац, судалгаа шинжилгээ, гарааны бизнес, ногоон ажил эрхлэлтийг дэмжинэ.
- 4.2.3. Хог хаягдлыг ялгах, дахин боловсруулах, байгальд ээлтэй аргаар устгах технологи, менежментийг судлан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлж, Хог хаягдлын цэгийг камержуулж нэгдсэн хашаажуулалт хийнэ.
- 4.2.4. Хөдөөгийн багуудад малын сэг зэм устгах харуул хамгаалалттай цэг бий болгоно.

ТАВ. ДЭД БҮТЭЦ

- 5.1.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн дагуу шинээр олгож байгаа суурьшлийн бүсийн айл өрх, үйлчилгээний газруудыг цахилгаанаар хангах арга хэмжээ авна.
- 5.1.2. Сумын төвийн дулааны төвлөрсөн инженерийн шугам сүлжээний зураг төсвийн дагуу шинэчилнэ.
- 5.1.3. Сумын төвийн үер уснаас хамгаалах үерийн даланг зураг төсвийн дагуу барьж байгуулна.
- 5.1.4. Орон нутгийн чанартай зам даваануудыг засч сайжруулан, тэмдэгжүүлж, аюулгүй байдлыг хангахад анхаарна.
- 5.1.5. Сумын хилийн цэс, нутгийн зарим маргаантай заагуудын тал элдээх аймаг сумдын удирдлагуудтай тохиролцож, засгийн газарт тавьж шийдвэрлүүлэнэ.
- 5.1.6. Сумын төвийн нийтийн эзэмшилийн газруудад хяналтын камерыг нэмэгдүүлнэ.



— оо —



12

0000000012

